

Батлав: Сургалтын менежер Х.Орломжав

ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Бүлэг №2. Хичээл № 11

Хичээлийн сэдэв: Шинэ жил

Хамрах хүрээ: 12 жилийн сургалттай 8р анги

Хичээлийн хугацаа: 40 минут

Анги зохион байгуулалт: Ганцаарчилсан болон анги нийтээрээ

Хичээлийн агуулга: Shapes, түүний хэрэглээ

Хичээлийн зорилго: Дүрсээр зохиомж хийж сурах

Хичээлийн зорилт:

- Дүрс сонгох
- Дүрс үүсгэх
- Дүрс будах
- Дүрсийг хэлбэржүүлэн зохиомжлох

Хүлээгдэж буй үр дүн:

Нийт суралцагчдад: Дүрсийг сонгож, үүсгэж сурна

Ихэнх суралцагчдад: Сонгосон дүрсийнхээ хэмжээг өөрчлөх, өнгө оруулж сурна

Цөөн суралцагчдад: Дүрсээр зохиомж хийж сурна

Хэрэглэгдэхүүн: Компьютер, проектор, төрөл бүрийн цаасан дүрсүүд, MS Word2007 программ, цавуу, ppt файл

Арга зүй: Төсөөлөн загварчлах үйлийг баримжаалан мэдлэг бүтээх

Хичээлийн үнэлгээ: Багш тусгайлан бэлдсэн үнэлгээний хуудсаар сурагчдыг үнэлнэ.

Онц 
сайн 
дунд 

Хичээлийн явц:

Хичээлийн элемент	Хугацаа	Суралцах үйл ажиллагаа, Багшийн асуулт, хариулт (Б), Сурагчийн асуулт, хариулт (С)	☆ Үнэлгээ, ● Багшийн санал ♣ Анхаарах зүйл
Анги зохион байгуулалт	1мин	Б: Сурагчидтай мэндлэх С: Багштай мэндлэн хичээлийн хэрэгслээ бэлтгэнэ.	
Сэдэл төрүүлэх Сэргээн сануулах шат	10 мин	Б: Бичлэг үзүүлнэ. Энэ бичлэгийг үзээд ямар сэтгэгдэл төрснөө багшдаа хэлээрэй. С: бичлэгээ үзнэ, сэтгэгдлээ хэлнэ. Б: За тэгвэл өнөөдрийн хичээлийн сэдэв...? С: Шинэ жил ... Б: Багш дүрсүүд тарааж өгнө. Б: Шинэ жилийн тухай төсөөллөө өгөгдсөн дүрсээр илэрхийлээрэй.	♣хүүхэд бүрийг асуултад хариулж оролцоход нь анхаарах дэмжих. ♣Компьютерийг асааж бэлдсэн байна. ☆ сурагчид нэг бүрийг сайшаах Дэвтэрт наалгана. Дүрс дэвтэрт наахаар хэмжээтэй байна.
Шинэ мэдлэг бүтээх	10 мин	Б: Хүүхдүүдээ, өмнөх мэдлэгээ ашиглан дэвтэртээ буулгасан биетээ компьютерт үүсгэж үзье. С: Сурагчид хийсэн биетээ MS Word Insert–Shapes ашиглан хийнэ. С: Дүрс ашиглан биет үүсгэх алхмуудыг (MS Word Insert–shapes) дэвтэртээ тэмдэглэж авна.	☆ стандарт бус үнэлгээгээр явцын дунд үнэлэх ♣ хүүхэд бүр тэмдэглэл хийж буй эсэхэд анхаарах. ♣Сурагчид гаргаж чадахгүй тохиолдолд багш дагуулж хийнэ. /алхам бүрийг харуулна/
Бататгал дүгнэлт	15 мин	Б: Insert–shapes хэрэгслийг ашиглан хийсэн зохиомж харуулна. С: Өөрсдийн хийсэн зохиомжоо хөгжүүлнэ. Б: Хичээлийн зорилго зорилтыг ppt харуулж, зорилгодоо хүрсэн эсэхийг дүгнэж ярилцана.	☆сурагчдын хариултанд үнэлгээ өгөх
Үнэлгээ	3 мин	Б: Сурагч тухайн хичээлийг ойлгосон түвшиндээ тохируулан үнэлгээний хуудсыг өргөнө.	☆ Багш үнэлгээний хуудсыг тарааж өгнө.
Гэрийн даалгавар	1 мин	1. Дүрс үүсгэх алхмуудыг сэргээж дэвтэртээ бичнэ. 2. Дүрс ашиглан дэвтэртээ зохиомж бэлдэж ирнэ.	









